



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 655

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 107,698,584.32 /нэг зуун долоон сая зургаан зуун ерэн найман мянга таван зуун наян дөрвөн төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн балансын үнэ, 4,861,834.00 /дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга найман зуун гучин дөрвөн / төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймгийн онцгой байдлын газрын дарга Д.Одонбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 8 дугаар сарын 08 өдрийн
655 дугаар тогтоолын хавсралт

**Өвөрхангай аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарт
эзэмшүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элдэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Албан контор /сахиулын байр/	1974	м.кв	62	5,948,239.70	1,883,609.27	4,064,630.43
2	Автомашин хадгалах байр	1974	м.кв	726	77,120,344.62	2,978,224.73	74,142,119.89
	Нийт дүн				83,068,584.32	4,861,834.00	78,206,750.32
					/наян гурван сая жаран найман мянга таван зуун наян дөрвөн төгрөг гучин хоёр мөнгө/	/дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг/	/далан найман сая хоёр зуун зургаан мянга долоон зуун тавин төгрөг гучин хоёр мөнгө/

Д/д	Хөрөнгийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Нэгж талбарын дугаар	Хэмжих нэгж	Хэмжээ	Эзэмших эрхийн үнэ /төгрөг/
1	Автомашин хадгалах байрны газар	Г-10180006804	6216000547	м.кв	4926	24,630,000.00
	Нийт дүн				4926	24,630,000.00
					/дөрвөн мянга есөн зуун хорин зургаа/	/хорин дөрвөн сая зургаан зуун гучин мянга/